




7th Story

Шуургыг намдаав

Calming the Storm

Шуургыг намдаав!

– 7th Story –



Эйль(шувуу): Сайн байцгаана уу~!! Намайг Эйль гэдэг. Би өнөөдөр та нарт нэг зүйлийг сонсох гэж байна. Та нарын харсанчлан би өдөр бүр ийш тийш нисэж явдаг нь миний ажил л даа. Хэд хоногийн өмнө хүмүүс завинд суухыг харсан юм. Бас л өдөр бүр хардаг ажил. Энэ тосгоны хүмүүс загас барихаар явах бүртээ завинд сууцгаадаг. Харин энэ өдөр өөр байсан. Байнга хардаг жирийн загас барилт биш байсан.

Петр Хөөё, нааш ир, за одоо завиа хөдөлгөө. Бүгдээрээ загас барих уу?

Иаков Тэгье ээ, бариагүй уджээ, одоо нэг чадвараа харуулах уу даа?

Иохан Надад ч сайхан байна. Хэр их загас барих бол?

Шавь нар Ок, явцгаая

Петр Багшаа, та эхлээд сууна уу.

Эйль(шувуу) Тэр хүмүүс хэсэг хугацааны дараа хол очсон. Гэвч удалгүй цаг агаар муудаж эхэлсэн. Би ч гэсэн нисээд дагаж явахад хүртэл бэрх байсан. Тэгээд би шон дээр суугаад намжихыг л хүлээх хэрэгтэй болсон. Хүлээхээс өөр юу ч хийж чадахгүй байв. Цаг агаар үнэхээр хувирамтгай байгаа биз? Цаг агаар маш гоё байснаа гэнэт шуурга дэгдээд.

Шавь нар аа аа аа !!!! Бид бүгд үхэх нь ээ ~~~~

Искарриотын Иудас Бид үхсэн~~~үгүй ээ үгүй бид амьдарсан ~~~ гэхдээ бид үхэх шахсан~

Андрей Есүс дээр очъё~ Есүс тусалж чадах байх ~

Томас Есүс загас барьдаг загасчин биш шүү дээ?

Андрей Тэгсэн ч гэсэн очно

Томас Тэгвэл би ч гэсэн очно оо


Андрей Есүс ээ Есүс ээ~!! Туслаарай, бид бүгд усанд автаж үхэх нь!

Есүс (нойрноосоо сэрэн эвшээлгээд) айн, юу гэнээ?

Андрей Үнэхээр том ширүүн шуурга дэгдлээ. Танд сонсогдохгүй байна уу?



Томас	Мэдрэхгүй байна уу?
Есүс	(санаа алдан) Юунд тэгтлээ айцгаана вэ? Өчүүхэн итгэлтнүүд ээ...
Андрей, Томас	(байж боломгүй мэт) айн?
Есүс	Ирээд үз
Шавь нар	Аааааааааааааа!!
Искарриотын Иудас	Бид үхэх нь ~~
Есүс	Боль боль! Шавь нар аа! ~! Үхүүлэх нь Миний хүсэл биш. <ahem> Салхиа ~ чи боль !! Далай, чи болигтун!! Бүгд болигтун ~!!
Эйль(шувуу)	Түүнийг айлдангуут шуурга намдсан. Миний үг үнэн байгаа биз? Тоглоом биш биз дээ? Энэ хүн, үгүй ээ үгүй. Тэр цаг агаартай ч ярилцсан. Дээр нь цаг агаар үнэхээр хэлснийх нь дагуу намдсан!!
Иаков	өө ... яанаа ...
Филип	Ээ ... Энмана ...
Бартоломай	Яа ... яаж ...
Симон	Би мэдэж байсан ...
Томас	Чи? Хөөш ... чи дөнгөж саяхан л гэлээ дээ? Айн?
Есүс	хүмүүс ээ ... гэхдээ би буцаж очоод жаахан унтаж болох уу?
Иохан	Өө тэгэлгүй яахав... багш аа... унтаж байхад чинь сэрээсэнд уучлаарай.
Иаков	Ер нь ямар хүн болохыг ч мэдэхгүй юм. Ингэхэд салхи, далайг зэмлэдэг хүн байдаг уу?
Филип	Харин тийм ээ. Үнэндээ би ч гэсэн хийж үзсэн байхгүй юу. Салхиа намдагтун~ Би хэтэрхий их кино үзсэн юм болов уу? Есүс жинхэнээсээ ирсэн ...
Бартоломай	Үнэн шүү, үнэхээр үнэн
Эйль(шувуу)	Яаж ч бодсон миний сая харсан зүйл үнэхээр хүний хийж чадах зүйл биш байсан. Төстэй явдлыг ч харж байгаагүй. Би ч гэсэн энэ хүнийг дагаж явна. Одоохондоо Есүсийг ямар хүн болохыг сайн мэдэхгүй ч, харсан зүйлээ баттай хэлж чадна. Түүний дараа шавь нар нь дахин загас барьж завиа нуурын нөгөө талын эрэг дээр тавив. Завь зогсмогц гэнэт хоёр галзуу хүн тэр булшнаас гарч ирсэн.
Галзуу	аааааааааа~!!!
Шавь нар	аааааааааааааааа~!!!
Есүс	хөөе ... та нар одоо жаахан айхаа болих юм биш үү?



- Петр** тийм шүү уучлаарай.
- Галзуу 1** Бидэнд хүссэн зүйл юу гээч Бурханы Хүү~
- Галзуу 2** Та Өөрийнхөө цагийг болохоос өмнө биднийг зовоох гэж ирсэн үү?
- Иохан** Багш аа, тэр одоо юу гээд байна аа?
- Есүс** Чи тэднээс холдож зайл.
- Галзуу1** Биднийг хөөе гэвэл тэр гахайн сүрэгт оруулаач!
- Есүс** Зайлагтун
- Эйль шувуу** Би бүгдийг харж сонссон шүү дээ? Тэр хоёр галзуу Есүстэй ярьж байгаад юу гэсэн гээч? Бурханы Хүү гэсэн шүү дээ. Би анх удаа л тийм үг сонссон байхгүй юу. Есүс зайлагтун гэж хэлмэгц хоёр галзуу нам жим болсон чинь нөгөөх гахайн сүрэг гэнэт галзууран давхиж эхэлсэн. Тэгтэл гахайнууд нэг нэгээрээ давхилдсанаа айх ч үгүй шууд ус руу орцгоосон. Энэ үнэхээр, бүр хачин гээч? Есүс бол миний харсан ямар ч хүнээс өөр байсан. Нээрээ шүү.
- Есүс** Одоо ямар байна?
- Галзуу 1** өө .. би .. яаж талархах ёстойгоо мэдэхгүй байна. Эзэн минь, баярлалаа
- Галзуу 2** Баярлалаа, баярлалаа